



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 11 сарын 13-и
Дугаар 62

Уланбаатар хот

Орон нутгийн ёмчит үйлдвэрийн газар байгуулж,
дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.1.3-ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн ёмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 2а/2594 тоот албан бичгээр өргөн барьсан саналыг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон сууц ашиглалтын Орон нутгийн ёмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Орон сууц нийтийн аж ахуйн газрын харьяа салбар байсан "Таван шар", "Москва"" салбарыг "Таван шар-Өргөө", "Москва-Өргөө" Орон нутгийн ёмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгож вөрчилсүгэй.

3. Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын дүрмийг хоёрдугаар, Орон нутгийн ёмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын дүрмийг гуравдугаар хавсралтаар тус, тус баталсугай.

4. Орон сууц, ашиглалтын Орон нутгийн ёмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог баталж, менежментийн гэрээгээр ажиллаж байсан зарим компаниудын веерийн эзэмшлийн газар болон хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн барилгын ажлын төсөв, гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллагаар хянуулах, хөрөнгийн үнэлгээг баталгаажуулан, холбогдох саналыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТТУЛГА

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 11
дугаар тогтолцын наадам ээр
хавсралт



Шинээр байгуулагдах үйлдвэрийн газруудын нэр

№	Менежментийн гэрээтэй байсан компаниуд	Шинээр байгуулагдсан ОНӨААТҮГ
1	"Сан Комфорт" ХХК	"Энх тулга-Өргөө" ОНӨААТҮГ
2	"Дулаан өргөө" ХХК	"Бат дулаан-Өргөө" ОНӨААТҮГ
3	"Эма энд би" ХХК	"Чин хүрээ-Өргөө" ОНӨААТҮГ
4	"Өнөр хотхон" ХХК	"Өнөр тулга -Өргөө" ОНӨААТҮГ
5	"Өнөр горхи" ХХК	"Өнөр энх-Өргөө" ОНӨААТҮГ
6	"Хайрхан уул Өргөө" ХХК	"Түшээ дунд гол-Өргөө" ОНӨААТҮГ
7	"Сансар өргөө" ХХК	"Дэнж сансар-Өргөө" ОНӨААТҮГ
8	"ГМ" ХХК	"Дэнж найрамдал- Өргөө" ОНӨААТҮГ
9	"Хаусинг сервис" ХХК	"Их алтан тэвш-Өргөө" ОНӨААТҮГ
10	"Эцэг эх хүү" ХХК	"Улаан хуаран-Өргөө" ОНӨААТҮГ
11	"Ашид үндрах" ХХК	"Ашид мэнх-Өргөө" ОНӨААТҮГ
12	"Симс" ХХК	"Ганзам-Өргөө" ОНӨААТҮГ
13	"Хөх асар" ХХК	"Хүрээ дэнж өргөө" ОНӨААТҮГ
14	"Хөх асар" ХХК	"Гандан дэнж-Өргөө" ОНӨААТҮГ
15	"Санни хаус" ХХК	"Баруун их нарлаг-Өргөө" ОНӨААТҮГ
16	"Санни хаус" ХХК	"Шинэ хороолол-Өргөө" ОНӨААТҮГ
17	"Ивэн эх" ХХК	
18	"Опен хаус" ХХК	"Зүүн сэлбэ-Өргөө" ОНӨААТҮГ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлдэг "....." НӨААТҮГ нь өөрт нь олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

1.2. "....." НӨААТҮГ (цаашид "үйлдвэрийн газар" гэх) нь Монгол Улсын "Иргэний хууль", "Терийн болон орон нутгийн өмчийн тухай", "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай", "Төсвийн тухай", "Эрчим хүчний тухай хууль", "Хот суурины ус хангамжийн ариутгах татуургын ашиглалтын тухай хууль", "Компанийн тухай", "Хөдөлмөрийн тухай" "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, мериийн хөтөлбөр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлдэг "....." НӨААТҮГ-ын дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. "....." НӨААТҮГ-ын өмчлөгч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Нийслэлийн Засаг даргаас эрх олгосон терийн захиргааны байгууллага болох Нийслэлийн Өмчийн харилцааны газар байна.

ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

2.1. Үйлдвэрийн газрын оноосон бүрэн нэр нь "....." нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь "....." НӨААТҮГ байна.

2.2. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Монгол улс

2.3. Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг: Монгол улс
2.4. Электрон шуудангийн хаяг: E-mail:

ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БЭЛЭГДЭЛ, ТЭМДЭГ

- 3.1. "....." НӨААТҮГ нь өөрийн бэлэгдэлтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 3.2. Бэлэгдэл, тэмдгийн загварыг захирал баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг үйлдвэрийн газар эдслинэ.
- 3.3. Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.
- 3.4. Тэмдгийг үйлдвэрийн газрын захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

- 4.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь хариуцсан нутаг дэвсгэрт орших аж ахуйн нэгж, оршин суугчдын орон сууцны инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, техникийн ашиглалтанд хяналт тавих, хэвийн найдвартай үйл ажиллагааг бүрэн ханганд ажиллахад оршино.
- 4.2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Улаанбаатар хотын өөрийн харьянны ус дулаан дамжуулах төв болон инженерийн шугам сүлжээн дээр үйл ажиллагаа явуулдаг орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгэ, түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх явдал мөн.
- 4.3. Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ /орон сууцны оршин суугч хүн ам, аж ахуйн нэгж байгууллагуудад хэрэглээний халуун хүйтэн ус түгээж бохирыг татан зайлзуулах, дулаанаар хангах, инженерийн шугам сүлжээ тоног төхөөрөөмжид засвар үйлчилгээ хийх зэрэг/
- 4.4. Үйлдвэрийн газрын дүрэмд орсон вөрчлөлтүүдийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хучин төгөлдөр болно.
- 4.5. Үйлдвэрийн газрыг хувьчлах, вөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаа нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдана.
- 4.6. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах, вөрчлөн байгуулах, татан буулглахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.